

**БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

ЦАГААНХҮҮГИЙН ИДЭРБАТ

**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.3.9-д “Давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.” гэж, 6.4-т “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх, чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна” гэж, 7.3.22-т “Гамшгийн аюул, өртөнг, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно” гэж, 8.3.2-т “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд дасан зохицох, эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх, хөдөө аж ахуйд даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, гэнэтийн эрсдэлээс учирч болох эдийн засгийн хохирол, эрсдэлийг бууруулна” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.4.9-д “Байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулна” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн 3.7.3-т “гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, давхар даатгалын тогтолцоог бий болгох нөхцөлийг бүрдүүлэх” гэж тус тус заасан.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Дэлхийн дахинд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр гамшгийн тохиолдол сүүлийн 20 жилд харьцангуй нэмэгдсэн, 2021-2030 онд гамшгийн тохиолдол 40 орчим хувиар нэмэгдэх магадлалтай байна. Монгол улс нь газар зүйн байршлын хувьд Евроазийн эх газрын төвд сэрүүн уур амьсгалын бүсэд орших далайд гарцгүй, эмзэг экосистем, байгаль цаг агаараас хараат эдийн засгийн тогтолцоо зэргээсээ шалтгаалан уур амьсгалын өөрчлөлтөд нэн өртөмтгий байдаг.

Малчдын аж амьдралд байгалийн гаралтай харилцан уялдаатай эрсдэлийн төрөл болох гангаас үүдэлтэй зудын эрсдэл элбэг тохиолддог. Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ус, цаг агаарын гаралтай гамшиг, аюулт үзэгдлийн тоо 2015 онтой харьцуулахад 2021 онд 2.9 дахин нэмэгдсэн байна. Зуд болон ган-зуд

дараалсан гамшгийг хамтад нь оруулан зудын эрсдэлийг 2020-2022, 2030, 2050 оноор тооцож гаргасан судалгаагаар 2030 оны үед зудын эрсдэл их зэрэглэлд байх газар нутгийн хэмжээ 2020-2022 оны дунджаас 14.4%, нэн их эрсдэлтэй байх нутаг 3.4% хувиар нэмэгдэх төлөвтэй, харин 2050 онд манай орны ихэнхи нутгийг хамрах буюу зудын эрсдэл “Нэн их” зэрэгт хүрэх нутаг дэвсгэрийн хэмжээ 2020-2022 оны дундажтай харьцуулахад даруй 35 дахин нэмэгдэх ба ган зудаас хамаарах малын зүй бус хорогдол 9.4% болж нэмэгдэх үр дүн гарсан нь зудын гамшгийн эрсдэлийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө улам нэмэгдэхээр байна. Иймд тохиолдох нь нэгэнт тодорхой байгаа байгалийн аюулт үзэгдлийн учирч болзошгүй эрсдэлийн тохиолдох боломжийг бууруулах зохистой арга хэмжээг эртнээс бэлтгэн урьдчилан авч, үр дагаврыг нь багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхийн тулд гамшгийн эрсдэлийг бууруулах зөв зохистой бүтэц, тогтолцооноос гадна зориулалтын бөгөөд хүрэлцэхүйц санхүүгийн эх үүсвэр нэн шаардлагатай.

Олон улсын туршлагаас харахад гамшгийг урьдчилан харж, болзошгүй эрсдэлийг бууруулах нь түүнээс учрах хор хохирлыг арилгах үйл ажиллагаанаас 15-20 дахин бага зардал шаардана гэдгийг тогтоосон.

Байгалийн хүчин зүйлийн нөлөөлөл, зүй тогтол, хувьсал өөрчлөлтийн нөлөөний үр дүнд үүсэх аюул буурахгүй ч нэрвэгдэгч бүрт дундаж үр дагавартай байхаар том бүлгийн хүрээнд түүний магадлал, үр дагаврыг сулруулах эрсдэлийг шилжүүлэх, хуваах, тархаах стратегийн арга хэрэгсэл нь даатгал, олон улсын давхар даатгалын систем бөгөөд даатгалын хураамжийн хуримтлал болон гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн бусад тохиромжтой эх үүсвэрүүдийг ашиглан гамшгийн эрсдэлийн сан үүсгэж гамшгийн үр дагаврыг даван туулах нь олон улс оронд түгээмэл хэрэглэгдэж байна.

Гамшигт өртсөн тохиолдолд маш богино хугацаанд үр дүнтэйгээр сэргэн хөгжих чадвартай байна гэдэг нь гамшгийг даван туулах чадавх буюу хэмжүүр нь юм. Иймд уламжлалт мал аж ахуйг хамгаалах, малчин өрхийн эрсдэл тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх, өртөнг, эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн төрийн чиг үүргийн байгууллагуудын хамтран хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, малчин өрхийн гамшгийн эрсдэлийг бууруулах зориулалт бүхий санг үүсгэх хууль, эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн гамшигт үзэгдэл нь аймаг сумдын газар зүйн байршил, цаг уурын нөхцөл байдлаас хамааран харилцан адилгүй тохиолддог ба малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр олгох босго үзүүлэлт нь малчдын даатгалд хамрагдах сонирхлыг бууруулж, даатгалын үр шимийг хүртэхэд сөргөөр нөлөөлдөг байна. Иймд босго үзүүлэлтийг малын хорогдлын түүхэн мэдээнд үндэслэн бодитой тогтоох нь малчдын даатгалын үр шимийг хүртэх, хамрагдалтыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Иймд малчдын өмнө тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэхдээ актуар тооцоололд үндэслэн дундаж малын хорогдлыг тооцон босго үзүүлэлтийг 5 хувь болгон бууруулснаар нөхөн төлбөр тодорхой давтамжтай олгогдох замаар малчид даатгалын үр шимийг хүртэх, малын индексжүүлсэн даатгалын тогтолцоог урт хугацаанд, тогтвортой өргөжин тэлэх ач холбогдлыг өгөх болно.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-т заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төслөөр даатгалын нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг бууруулж 5 хувь болгох зохицуулалтыг тусгана.

Мөн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган, зудын аюулын улмаас малчдад нүүрлэж буй гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг дэмжих санхүүгийн эх үүсвэрийг бий болгох эрх зүйн үндсийг тогтоож, даатгуулагчийн гамшгийн эрсдэлийн хор уршиг, хохирол, сөрөг үр дагавраас зайлсхийх, таслан зогсоох, бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох уламжлалт мал ахуй эрхлэгч малчид /даатгуулагчид/-ын эрх ашгийг хамгаалах урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрэлдэн бий болж, гамшгийн дараах хохирлыг арилгах төрд ирэх санхүүгийн ачаалал буурах, чиг үүргийн байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд гамшгийн эрсдэлийг бууруулах төрийн бодлого цогцоор хэрэгжих боломж бүрдэж даатгуулагч гамшгийн эрсдэлийг хүлээн авч дасан зохицох, хохирол багатай даван туулах ач холбогдолтой.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан “Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

--oOo--